

**“МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЯВУУЛСАН ТАЛААРХ БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2020 оны 08 дугаар  
сарын 25-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд**

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2020 оны 08 дугаар сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2020 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2020 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаараа тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явууллаа.

Байнгын хорооны хуралдааны хэлэлцүүлгийн үед Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор “төслийн хавсралтын гуравдугаар бүлэгт “Сэлэнгэ аймгийн төвд 50 МВт хүчин чадалтай цахилгаан станц барих” гэж нэмэх”, Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэг “төслийн хавсралтын Ногоон хөгжлийн бодлого тавдугаар бүлгийн зорилтод “Байгалийн” гэсний өмнө “Байгаль орчныг хамгаалах” гэж нэмэх”, “төслийн хавсралтын Ногоон хөгжлийн бодлого тавдугаар бүлгийн 12 дахь заалтын “дасан зохицох” гэсний дараа “бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжлийн” гэж нэмэх”, “төслийн хавсралтын Эдийн засгийн бодлого гуравдугаар бүлгийн “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр” гэсэн хэсгийн 3 дахь заалтын “нөхөн сэргээх” гэсний дараа “доройтсон бэлчээрийг өнжөөх, нөхөн сэргээх замаар хамгаалж, бэлчээр ашиглалтын ачааллыг тэнцвэржүүлэн” гэж нэмэх”, “төслийн хавсралтын Эдийн засгийн бодлого гуравдугаар бүлгийн “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр” гэсэн хэсгийн 5 дахь заалтын “боловсруулах” гэсний дараа “байгальд ээлтэй” гэж нэмэх”, “төслийн хавсралтын Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого зургаадугаар бүлгийн “Улаанбаатар хот” гэсэн хэсгийн 4 дэх заалтад “Төр, иргэн, хувийн хэвшил болон бусад талын оролцоотойгоор агаарын бохирдлыг 80 хувь бууруулна” гэж нэмэх”, Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин “төслийн хавсралтын Эдийн засгийн бодлого гуравдугаар бүлгийн “Аялал жуулчлал” гэсэн хэсгийн 4 дэх заалтад “Дорноговь” гэж нэмэх”, “төслийн хавсралтын Эдийн засгийн бодлого гуравдугаар бүлгийн “Эрчим хүч” гэсэн хэсгийн 3 дахь заалтад “Дорноговь” гэж нэмэх”, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал “төслийн хавсралтын Эдийн засгийн бодлого гуравдугаар бүлгийн “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр” гэсэн хэсэгт “Малын тэжээлийн үндсэн бааз болсон бэлчээрийн ашиглалт хамгаалалт, сайжруулалтын эрх зүйн орчныг бүрдүүлж бэлчээрийн доройтол цөлжилтийг бууруулна.” гэж нэмэх”, “төслийн хавсралтын Эдийн засгийн бодлого гуравдугаар бүлгийн “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр” гэсэн хэсэгт “Мал аж ахуйг байгаль цаг уурын эрсдэлээс хамгаалах бэлтгэл бэлэн байдлыг хангах тогтолцоог боловсронгуй болгож, сумдад өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх, малчдыг өвс тэжээл нөөцлөх сүлжээг бий болгоно.”

гэж нэмэх", "төслийн хавсралтын Эдийн засгийн бодлого гуравдугаар бүлгийн "Аялал жуулчлал" гэсэн хэсэгт "Манзуширын түүхэн дурсгалт газрыг түшиглэн соёл, шашин, аялал жуулчлалын олон улсын цогцолбор байгуулах ажлыг эхлүүлэх" гэж нэмэх", Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд "төслийн хавсралтын Эдийн засгийн бодлого гуравдугаар бүлгийн "Эрчим хүч" гэсэн хэсэгт "Баянтээгийн 20 МВт-ын дулааны цахилгаан станц барих" гэж нэмэх", "төслийн хавсралтын Эдийн засгийн бодлого гуравдугаар бүлгийн "Аялал жуулчлал" гэсэн хэсгийн 1 дэх заалтын "Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл II-ийг" гэсний дараа "Өвөрхангай" гэж нэмэх", "төслийн хавсралтын Эдийн засгийн бодлого гуравдугаар бүлгийн "Тээвэр, логистик" гэсэн хэсгийн 4 дэх заалтад "Хархорин нисэх буудлыг 4 С ангиллын олон улсын нисэх онгоцны буудал болгох" гэж нэмэх" гэсэн санал тус тус гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.


Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал "төслийн хавсралтын Эдийн засгийн бодлого гуравдугаар бүлгийн "Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр" гэсэн хэсгийн 1 дэх заалтыг "Атрын IV аяныг хэрэгжүүлж, тариалангийн тогтвортой үйлдвэрлэлийн хөгжлийг хангаж, бүтээгдэхүүнийг экспортлох, боловсруулах хүчин чадлыг нэмэгдүүлж, бүтээгдэхүүний үнийг тогтвортой барих, таримлын сэлгээ, тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар салбарын бүтээмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ." гэж өөрчлөх", "төслийн хавсралтын Эдийн засгийн бодлого гуравдугаар бүлгийн "Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр" гэсэн хэсэгт "Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, үндэсний үйлдвэрт бүтээгдэхүүнээ нийлүүлсэн малчид, тариаланчдад төрөөс урамшуулал олгоно." гэж нэмэх гэсэн зарчмын зөрүүтэй саналууд гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

"Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлт болон зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,  
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**



**Х.БОЛОРЧУЛУУН**